



# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## Санхүүгийн аудитын тайлан

Говьсүмбэр аймгийн 2018 оны Төсвийн хуулийн  
хэрэгжилтийн явцад хийсэн аудитын тайлан



**ТӨСВИЙН ЗАХИРАГЧДЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН  
ХҮРЭХ ҮР ДҮНГ ТОДОРХОЙ БАТАЛДАГГҮЙГЭЭС ЗОРИЛТОТ  
ТҮВШИНД НИЙЦЭЖ БУЙГ ҮНЭЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.**

2018 он

## АГУУЛГА

<p><b>Тайланг бэлтгэсэн:</b></p> <p><b>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар</b></p> <p><b>Дарга, Тэргүүлэх аудитор</b> <b>Б.Сарантуяа</b></p> <p><b>Аудитын менежер</b> <b>Г.Наранбаяр</b></p> <p><b>Ахлах аудитор</b> <b>Ц.Батсайхан</b></p> <p><b>Аудитор</b> <b>Б.Анхтуяа</b></p> <p><b>2018 оны 11 дүгээр сар</b></p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7054-3151, 7054-3156, 7054-3179 дугаарын утсаар харилцана уу.</p> <p><b>ХАЯГ:</b> <b>Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 давхар, 208 тоот</b></p>	<p>Товчилсон үгийн тайлбар .....3</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....4-5</p> <p><b>БҮЛЭГ 1. УИХ-аас баталсан төсвийг жил бүр нэмэгдүүлэн баталж байгаа нь төлөвлөлт бодитой бус, үндэслэлгүй байгааг харуулж байна.</b></p> <p>1.1. ТЕЗ-ийн 2018 оны төсвийг Сангийн яамнаас ирүүлсэн удирдамжийн дагуу боловсруулсан байна</p> <p>1.2. Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг бодит тооцоо судалгаагүй, үндэслэлгүй төлөвлөснөөс аймгийн ИТХ-аар нэмэгдүүлэн баталж байна.</p> <p>1.3. Тус аймаг нь 2018 онд улсын төсөвт орлого төвлөрүүлэхгүй, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авахгүй байхаар батлагдсан байна.</p> <p><b>БҮЛЭГ 2. Татварын орлогын төлөвлөгөө жил бүр давж биелж байгаа нь орлого нэмэгдүүлэх нөөц боломж байгааг харуулж байна.</b></p> <p>2.1. Орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 213.0 сая төгрөг буюу 6.2%-иар давж биелсэн байна.</p> <p>2.2. Төсөвт байгууллагын өөрийн орлого болон өмнөх оны татварын өрийн судалгаа гаргаж тооцооноор орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэх боломжтой байна.</p> <p><b>БҮЛЭГ 3. Төсвийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйгээс бодит бус хэмнэлт үүссэн байна.</b></p> <p>3.1. Төсвийн хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.</p> <p>3.2. Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.</p> <p><b>БҮЛЭГ 4. Төсөв захирагчдын хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг тодорхой батлаагүйгээс дүгнэлт өгөх боломжгүй байна.</b></p> <p>4.1. Төсөв захирагчдын хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг тодорхой батлаагүй байна.</p> <p>4.2. Төсөв захирагчид 2018 оны Төсвийн хуулиар батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд дүгнэлт өгөх боломжгүй байна.</p> <p>4.3. Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.</p> <p><b>Дүгнэлт</b></p> <p><b>Зөвлөмж</b></p> <p><b>Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал</b></p> <p><b>Холбогдох байгууллагаас ирүүлсэн саналд өгсөн тайлбар</b></p> <p><b>Хавсралтууд</b></p>
---	---

## Товчилсон үгийн тайлбар

<b>ААНБ</b>	Аж ахуй нэгж байгууллага
<b>АЗДТГ</b>	Аймгийн Засаг даргын тамгын газар
<b>АИТХ</b>	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>АОНХС</b>	Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан
<b>АТБӨАХАТ</b>	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
<b>АШБ</b>	Анхан шатны баримт
<b>БТСГ</b>	Биеийн тамир, спортын газар
<b>БСШУСЯ</b>	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын яам
<b>ГБХЗХГ</b>	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
<b>ГХУСАХХ</b>	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ
<b>ГХБХБГ</b>	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>МУ</b>	Монгол Улсын
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ОАТ</b>	Орлогын албан татвар
<b>ОНӨГ</b>	Орон нутгийн өмчийн газар
<b>ОНӨААТҮГ</b>	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ОУВС</b>	Олон улсын валютын сан
<b>СХС</b>	Сум хөгжүүлэх сан
<b>СТСХ</b>	Санхүү, төрийн сангийн хэлтэс
<b>ССЗДТГ</b>	Сүмбэр сумын Засаг даргын тамгын газар
<b>ТБОНӨХБАҮХАТХ</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
<b>ТЕГ</b>	Татварын ерөнхий газар
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>ТЗШ</b>	Тусгай зориулалтын шилжүүлэг
<b>ТТАМНАТ</b>	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
<b>ТШЗ</b>	Төсвийн шууд захирагч
<b>ТЭЗҮ</b>	Техник эдийн засгийн үндэслэл
<b>УИХ</b>	Улсын их хурал
<b>УТХ</b>	Улсын тэмдэгтийн хураамж
<b>ҮХЭХ</b>	Үл хөдлөх эд хөрөнгө
<b>ХХОАТ</b>	Хувь хүний орлогын албан татвар

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

### **1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг Төсвийн байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжийн дагуу Монгол Улсын Ерөнхий аудитор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

### **2. Аудитын зорилго, зорилт**

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцыг шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгч үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

### **3. Аудитын хамрах хүрээ**

Аудитыг ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд болон орон нутгийн ТЕЗ-ийн 2018 оны 3 дугаар улирлын байдлаарх орлого, зарлагын төлөвлөгөө гүйцэтгэл, холбогдох судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

### **4. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан Санхүүгийн аудитын болон Гүйцэтгэлийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### **5. Аудитын багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Б.Анхтуяа нар хийж гүйцэтгэлээ.

### **6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдсан мэдээлэл**

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд өгсөн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

## 7. Үндсэн мэдээлэл

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиудыг тус тус баталжээ.

2018 оны төсвийн тухай хуулиар тус аймагт орон нутгийн суурь орлого 4,875.3 сая, орон нутгийн суурь зарлага 4,175.7 сая, ТЗШ-ийн байгууллагын зарлага 8,356.9 сая, ОНХС-ийн зарлага 1,154.2 сая төгрөгөөр тус тус батлагдсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоолоор аймгийн 2018 оны төвийг батлахдаа УИХ-аас хянасан төсвийн орлого, зарлагыг 14.3% буюу нийт 1,960.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж баталсан байна.

Орон нутгийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн эсэх

# Бүлэг 1

УИХ-аас баталсан төсвийг жил бүр нэмэгдүүлэн баталж байгаа нь төлөвлөлт бодитой бус, үндэслэлгүй байгааг харуулж байна.

### 1.1 ТЕЗ-ийн 2018 оны төсвийг Сангийн яамнаас ирүүлсэн удирдамжийн дагуу боловсруулсан байна.

Сангийн сайдын 2017.07.04-ний өдрийн 4-1/4116 тоот албан бичгээр “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 оны төсвийн төсөл, 2019-2020 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамж”-ийг ирүүлсэн бөгөөд уг удирдамжийн дагуу аймгийн ТЕЗ-ийн 2018 оны төсвийн төсөл, 2019-2020 оны төсвийн төсөөллийг бэлтгэж, 2017 оны 08 дугаар сарын 09-ний өдөр Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийг 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Улсын Их Хурлаар хэлэлцэн баталсан байна.

Дээрх удирдамжийн дагуу боловсруулсан аймгийн ТЕЗ-ийн 2018 оны төсөвт дараах нийтлэг өөрчлөлтүүд тусгагджээ. Үүнд:

1. 2018 онд Говьсүмбэр аймаг улсын төсөвт орлого төвлөрүүлэхгүй, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авахгүй байхаар батлагдсан
2. Төрийн албан хаагчдын эрхэлж буй үйл ажиллагаа, ажлын бүтээмж, үр дүн, сахилга, хариуцлага, албан даалгаврын хэрэгжилт зэргийг харгалзан олгох “нэг удаагийн тэтгэмжийн зардал”-ыг албан хаагч тус бүрт 0.3 сая төгрөг олгохоор батлагдсан
3. Эдийн засаг, төсвийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалтын хэмжээ буурч байгааг харгалзан хөрөнгийн зардлын дэмжлэгийг орон нутгийн суурь зардалд тусгаж баталсан, Үүнтэй холбогдуулан орон нутагт үүссэн тулгамдсан асуудал, зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах зорилгоор аймаг бүрт хуваарилсан хөрөнгийн суурь зардлын 30-аас доошгүй хувийг сумын төсөвт тусган батлуулсан
4. Сангийн яам, Дэлхийн банкны хамтран хэрэгжүүлж буй “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд 2018 онд орон нутгийн хөгжлийн сангийн

- төсвийг дэмжих, сайн гүйцэтгэлийг урамшуулах зорилгоор сумдын ОНХС-д урамшуулал, дэмжлэгийг олгохоор төлөвлөсөн
5. Сүүлийн жилүүдэд төсвийн алдагдлыг бууруулах, зарлагын өсөлтийг хязгаарлах зорилгоор төсвийн хэмнэлтийн горимд шилжиж ажилласны дүнд орон нутгийн төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны зарим зардал хүрэлцэхгүй болж, өр төлбөр үүсч байгааг харгалзан бараа, үйлчилгээний зарим зардлын хэмжээг нэмэгдүүлсэн мөн сум, багийн түвшинд төрийн үйлчилгээг хүргэхэд шаардлагатай урсгал зардлыг нэмэгдүүлж баталсан
  6. ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай нэн ядуу иргэдэд олгодог тэтгэмж, дэмжлэгийг нэмэгдүүлэхээр тохиролцсоны дагуу “Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ”-ний зардлыг нэмэгдүүлсэн
  7. Нийгмийн халамжийн тэтгэвэр, асаргааны тэтгэмжийг инфляцийн түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэхээр төсвийн суурь зардалд нэмж тооцсон
  8. “Цалинтай ээж” хөтөлбөрийн дагуу 0-3 хүртэл насны хүүхдээ асарч буй эхэд сар бүр 50.0 мян.төгрөг, түүнчлэн 0-18 насны гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт улирал бүр 240.0 мянган төгрөгийг улсын төсвөөс олгохоор тооцсон
  9. Сул орон тоонд нөхөн томилгоо хийхэд баримтлах горимыг 2018 онд үргэлжлүүлэх
  10. Газрын тухай хуульд нийцүүлэн сумдын ЗДТГ-ын орон тоонд байсан “газрын даамал”-ын цалин сан, орон тоог ГХБХБГ-ын төсөвт шилжүүлэн батлуулсан байна.

## **1.2 Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг бодит тооцоо судалгаагүй, үндэслэлгүй төлөвлөснөөс аймгийн ИТХ-аар нэмэгдүүлэн баталж байна.**

Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг өмнөх онуудын суурь орлого, суурь зарлага болон төсөвт байгууллагуудын ирүүлсэн саналд үндэслэн төлөвлөдөг боловч төсвийн орлого, зардлыг хянаж, төлөвлөхөд ашиглах суурь судалгаа, тоон мэдээ багатайгаас төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдэж байна.


УИХ-аас аймгийн ТЕЗ-ийн 2018 оны орон нутгийн орлого 13,686.9 сая, төсвийн зарлага 13,686.9 сая төгрөгөөр батлагдаж ирсэн бөгөөд аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор орон нутгийн орлого, зарлагыг 1,960.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

### **2018 оны орон нутгийн төсвийн орлого төлөвлөлтийн талаар:**

Орон нутгийн татварын болон татварын бус орлогыг 2018 онд улсын төсөвт 1,987.0 сая, орон нутгийн төсөвт 4,825.7 сая төгрөг тус тус төвлөрүүлэхээр батлуулсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг өмнөх онтой харьцуулсан судалгааг графикаар харуулбал:

Улсын төсвийн орлогын төлөвлөгөө  
/сүүлийн 2 жилээр/



Графикаас харахад: 2018 оны улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг өмнөх онуудын гүйцэтгэлийн түвшинд тооцож төлөвлөөгүй байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөлтийг өмнөх жилүүдийн гүйцэтгэл болон тухайн жилийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байгаа боловч он дамжин төлөгдөх татварын авлагын тооцоо, тайлант онд шинээр үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын орлогын судалгааг үндэслэн улсын төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг үнэн зөв, бүрэн тооцож, төлөвлөөгүй байна. Тухайлбал: 2017 онд улсын төсвийн орлогын гүйцэтгэл 407.8 сая төгрөг буюу 21.1%-иар давж биелсэн байхад 2018 оны улсын төсвийн орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлээгүй байна.

УИХ-аас батлагдсан 2018 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	УИХ-аас баталсан орлого	Аймаг, сумдын баталсан орлого	Зөрүү
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	3,201.9	3 201,9	-
2	ХХОАТ-ын буцаан олголт	-300.0	- 300,0	-
3	ҮХЭХ-ийн албан татвар	250.0	250,0	-
4	АТБӨЯХ-ийн албан татвар	83.0	83,0	-
5	Улсын тэмдэгтийн хураамж	55.0	55,0	-
6	Газрын төлбөр	90.0	132,0	42,0
7	Ус ашигласны төлбөр	600.0	600,0	-
8	Ан амьтны нөөц ашигласны төлбөр			-
9	Дуудлага худалдааны орлого			-
10	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	40.0	40,0	-
11	Суутгагчийн хувь хүнд олгосон ОАТ	104.3	114,3	10,0
12	Үйл ажиллагааны орлого	102.5	145,9	43,4
13	Бууны албан татвар	4.7	4,7	-
14	ТТАМНАТ	0.5	0,5	-
15	Хог хаягдлын хураамж	82.5	87,5	5,0
<b>Аймгийн татварын орлогын нийт дүн</b>		<b>4 314.3</b>	<b>4 414,7</b>	<b>100.4</b>
1	Түрээсийн орлого	59.4	55,0	-4,4
2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	31.6	49,6	18,0
3	Хүү, торгуулийн орлого	280	356,0	76,0
<b>Аймгийн татварын бус орлогын нийт дүн</b>		<b>371.0</b>	<b>460,6</b>	<b>89,6</b>
1	Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг		-	-
2	Тусгай зориулалтын шилжүүлэг	8 324.4	8 324,4	-
3	Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	644.6	644,6	-
<b>Улсын төсвөөс авах шилжүүлгийн нийт дүн</b>		<b>8 969.0</b>	<b>8 969,0</b>	
1	ТЗШ-ийн өөрийн орлого	32.6	44,6	12,0
<b>ТЗШ-ийн өөрийн орлогын нийт дүн</b>		<b>32.6</b>	<b>44,6</b>	<b>12,0</b>
1	Өмнөх оны тэнцлийн ашгаас /ОНХС/		60,6	60,6
2	Өмнөх оны тэнцлийн ашгаас /Байгууллага/		216,3	216,3
<b>Өмнөх оны тэнцлийн ашгаас</b>		<b>-</b>	<b>276,9</b>	<b>276,9</b>
1	Өмнөх оны дансны үлдэгдэл /ОНХС/		556,2	556,2
<b>Өмнөх оны дансны үлдэгдэл /ОНХС/</b>		<b>-</b>	<b>556,2</b>	<b>556,2</b>
1	Сумдын Сум хөгжүүлэх сан		923,2	923,2

2	Сумдын Байгаль хамгаалах сан		-	-
3	Сумдын Мал хамгаалах сан		1,7	1,7
<b>Сумдын сангуудаас орох орлогын нийт дүн</b>			<b>924,9</b>	<b>924,9</b>
<b>НИЙТ ДҮН</b>		<b>13 687,0</b>	<b>15 646,9</b>	<b>1 959,9</b>

Хүснэгтээс харахад: Түрээсийн орлогыг 4.4 сая төгрөгөөр бууруулж, 8 нэр төрлийн орлогыг нэмэгдүүлэн баталсан байна. Тухайлбал: аймгийн татварын орлогыг 42.0 сая, татварын бус орлогыг 76.0 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогод автозамын орлогын 15.0 сая, ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлогыг 12.0 сая төгрөгөөр, сумдад татварын орлогыг 58.4 сая, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 3.0 сая, тусгай сангуудын орлогыг 924.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна. Сумдын тусгай сангуудын орлогын төлөвлөгөө бодитой бус, өмнөх оны орлогын гүйцэтгэлд үндэслээгүй, хэт өндөр байгаа нь Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс бүрдүүлэх нийт авлагын дүнгээр тооцож батлуулсантай холбоотой байна.

Орон нутгийн орлогын сүүлийн 2 жилийн төлөвлөгөөг харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

№	Орлогын нэр төрөл	2018 он	2017 он	Зөрүү
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	3 201,9	2 926,1	-275,7
2	ХХОАТ-ын буцаан олголт	-300,0	- 268,8	31,2
3	ҮХЭХ-ийн албан татвар	250,0	242,0	-8,0
4	АТБӨЯХ-ийн албан татвар	83,0	84,0	1,0
5	Улсын тэмдэгтийн хураамж	55,0	52,0	-3,0
6	Газрын төлбөр	132,0	90,0	-42,0
7	Ус ашигласны төлбөр	600,0	585,5	-14,5
8	Ан амьтны нөөц ашигласны төлбөр		-	-
9	Дуудлага худалдааны орлого		96,2	96,2
10	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	40,0	35,0	-5,0
11	Суутгагчийн хувь хүнд олгосон ОАТ	114,3	-	-114,3
12	Үйл ажиллагааны орлого	145,9	144,5	-1,4
13	Бууны албан татвар	4,7	4,5	-0,2
14	ТТАМНАТ	0,5	4,7	4,2
15	Хог хаягдлын хураамж	87,5	86,5	-1,0
<b>Аймгийн татварын орлогын нийт дүн</b>		<b>4 414,7</b>	<b>4 082,2</b>	<b>-332,5</b>
1	Түрээсийн орлого	55,0	55,0	-
2	Төсвийн байгууллагын өөрийн орлого	49,6	148,8	99,2
3	Хүү, торгуулийн орлогр	356,0	371,3	15,3
<b>Аймгийн татварын бус орлогын нийт дүн</b>		<b>460,6</b>	<b>575,1</b>	<b>114,6</b>
1	Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	-	-	-
2	Тусгай зориулалтын шилжүүлэг	8 324,4	8 091,6	-232,8
3	Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг	644,6	1 178,1	533,5
<b>Улсын төсвөөс авах шилжүүлгийн нийт дүн</b>		<b>8 969,0</b>	<b>9 269,7</b>	<b>300,7</b>
1	ТЗШ-ийн байгууллагын өөрийн орлого	44,6	52,7	8,1
<b>ТЗШ-ийн өөрийн орлогын нийт дүн</b>		<b>44,6</b>	<b>52,7</b>	<b>8,1</b>
1	Өмнөх оны тэнцлийн ашгаас /ОНХС/	60,6	798,8	738,2
2	Өмнөх оны тэнцлийн ашгаас /Байгууллага/	216,3	217,5	1,2
<b>Өмнөх оны тэнцлийн ашгаас</b>		<b>276,9</b>	<b>1 066,4</b>	<b>739,4</b>
1	Өмнөх оны дансны үлдэгдэл /ОНХС/	556,2	793,2	237,0
<b>Өмнөх оны дансны үлдэгдэл /ОНХС/</b>		<b>556,2</b>	<b>793,2</b>	<b>237,0</b>
1	Сумдын Сум хөгжүүлэх сан	923,2	1 035,8	112,6
2	Сумдын Байгаль хамгаалах сан	-	4,3	4,3
3	Сумдын Мал хамгаалах сан	1,7	15,2	13,5
<b>Сумдын сангуудаас орох орлогын нийт дүн</b>		<b>924,9</b>	<b>1 055,2</b>	<b>130,3</b>
<b>НИЙТ ДҮН</b>		<b>15 646,9</b>	<b>16 844,6</b>	<b>1 197,6</b>

Хүснэгтээс харахад: орон нутгийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 7.1% буюу нийт 1,197.6 сая төгрөгөөр бууруулан баталсан байна. Тухайлбал: татварын орлого нийт дүнгээрээ 8.1% буюу 322.5 сая төгрөгөөр нэмэгдсэн боловч татварын бус орлого 19.9% буюу 114.6 сая төгрөгөөр буурсан нь төсөвт байгууллагын өөрийн орлого буурсантай холбоотой байна. Мөн ОНХС-гийн орлогын шилжүүлэг, өмнөх



оны тэнцлийн ашиг, дансны үлдэгдэл зэрэг нь өмнөх оноос бага байгаа нь нөлөөлсөн байна.

2018 оны эхний 9 сарын байдлаар орон нутгийн орлогын төлөвлөгөөнд өөрчлөлт ороогүй байна.

### **2018 оны орон нутгийн төсвийн зарлага төлөвлөлтийн талаар:**

Аймгийн 2018 оны төсвийн зарлага 13,686.9 сая төгрөгөөр батлагдаж ирсэн байна. Үүнд: орон нутгийн суурь зарлага 4,175.8 сая, ТЗШ-ийн байгууллагын зарлага 8,356.9 сая, ОНХС-ийн зарлага 1,154.2 сая төгрөгөөр тус тус батлагдсан байна. Анх батлагдаж ирсэн төсвийн зарлагыг аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор нийт 1,960.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

УИХ болон аймаг, сумдын баталсан зарлагын төсвийг хүснэгтээр харуулбал:  
/сая төгрөгөөр/

Д/д	Зардлын төрөл	2018 онд батлагдсан төсөв		Зөрүү
		УИХ-аар батлагдсан	Аймаг, сумын ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлэн баталсан	
1	Орон нутгийн суурь зарлага	4,175.8	4,462.6	286.9
2	Тусгай зориулалтын шилжүүлгийн зарлага	8,356.9	8,368.9	12.0
3	Аймаг, сумын ОНХС-ийн зарлага	1,154.2	1,890.4	736.2
4	Сумдын СХС-ийн зарлага	0.0	924.9	924.9
<b>Нийт дүн</b>		<b>13,686.9</b>	<b>15,646.9</b>	<b>1,960.0</b>

Хүснэгтээс харахад: УИХ-аас хянасан төсвийг 14.3% буюу нийт 1,960.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Нэмэгдүүлж баталсан зардлыг төрлөөр нь авч үзвэл:

#### **1. Орон нутгийн суурь зарлагын 286.9 сая төгрөгийг:**

- Аймгийн Авто замын санд орлогын төлөвлөгөө батлагдаагүйгээс орлогын төлөвлөгөөг 15.0 сая төгрөгөөр баталж зардлыг нэмэгдүүлсэн,
- Орон нутгийн өмчийн газрын цалин сан дутуу батлагдсантай холбогдуулан цалин, НДШ-ийн зардалд 11.0 сая,
- Олон нийтийн цагдаагийн урамшууллын зардлыг 20.0 сая,
- Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан торгуулийн маягт хэвлүүлэх зардал, Замын цагдаагийн пост, Сүмбэр сумын камерын цахилгааны зардалд 8.8 сая, мөн ГХУСАХ-ний зардалд 30.0 сая нийт 38.8 сая,
- Аймгийн Татварын хэлтэс 2018 оноос шинэ байранд шилжин орох, аймгийн Архивын тасгийг Татварын хэлтсийн байранд шилжүүлэн байршуулахтай холбоотой зориулалтын тоног төхөөрөмж, бусад зардалд 13.2 сая,
- Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д “ахмад настан нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр харьяалал харгалзахгүй үнэ төлбөргүй зорчих” гэж заасны дагуу нийтийн тээврийн хэрэгслээр зорчих хөнгөлөлтөд 7.0 сая,
- ТЕГ-ын даргын 2012 оны 906 дугаар тушаалаар батлагдсан “Орон тооны бус байцаагч ажиллуулах журам”-д зохицуулагдсанаар 2018.01.01-ний өдрөөс Сүмбэр, Шивээговь сумдад орон тооны бус байцаагч ажиллуулах цалин, НДШ-ийн зардалд нийт 13.4 сая,

- Татварын хэлтэс нь 2018 онд шинэ байранд орохтой холбогдуулан сургалтын танхимд ширээ, сандал худалдан авах зардалд 10.0 сая,
  - Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1.2, 18.1.3 дахь заалтуудын дагуу түр хамгаалах байрыг зориулалтын дагуу явуулахад шаардлагатай бүтэц, орон тооны зардалд 4.5 сая,
  - Аймгийн Биеийн тамир спортын газрын Усан спорт, сургалтын төвийн ажилчдын орон тоо, цалин сан батлагдаж ирээгүй тул хэвийн үйл ажиллагааг хангахын тулд цалин сан, орон тооны асуудлыг шийдвэрлэхээр 40.0 сая,
  - Аймгийн ИТХ нь гүйцэтгэх ажилтаны орон тоог 2-оор нэмэгдүүлж цалингийн зардлыг 10.3 сая, хоолны унааны нэмэгдлийг 4.2 сая, НДШ-ийн зардлыг 1.7 сая, бичиг хэргийн зардлыг 0.3 сая, тээвэр шатахууны зардлыг 5.0 сая, урсгал засварын зардлыг 3.0 сая, дотоод албан томилолтын зардлыг 1.5 сая, цагаатгах ажлыг зохион байгуулах зардлыг 4.0 сая, орон нутгийн нөөц хөрөнгө 20.2 сая, ИТХ-д суудалтай намуудал олгох дэмжлэгийн зардал 17.0 сая, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 1.8 сая, нийт 69.0 сая,
  - Аймгийн Улаан загалмайн хороонд дэмжлэг 7.0 сая,
  - Сүмбэр сумын ИТХ нь иргэний танхимын ажилтны цалин, НДШ-ийн зардалд 3.2 сая, бичиг хэргийн зардалд 0.4 сая, урсгал засварын зардлыг 0.4 сая нийт 4.0 сая,
  - Сүмбэр сумын ЗДТГ нь сумын Засаг даргын нөөц хөрөнгө 6.0 сая,
  - Шивээговь сумын ИТХ нь иргэний танхимын ажилтны цалин, НДШ-ийн зардал 5.0 сая,
  - “Тохижилт сүмбэр” ОНӨААТҮГ нь ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын засвар үйлчилгээний зардалд 20.0 сая, гэрэлтүүлгийн зардалд 3.0 сая, нийт 23.0 сая,
2. **Тусгай зориулалтын шилжүүлгийн зарлагын 12.0 сая төгрөгийг:** Аймгийн БТСГ-ын өөрийн орлогын төлөвлөгөөг 12.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж, бичиг хэргийн зардал 0.4 сая, шуудан холбоо интернетийн төлбөр 0.5 сая, биеийн тамирын уралдаан тэмцээний зардал 11.0 сая, урсгал засварын зардал 0.1 сая, нийт 12.0 сая,
3. **Аймаг сумын ОНХС-гийн зарлагын 736.1 сая төгрөгийг:** ОНХС-гийн эхний үлдэгдлээс аймгийн ОНХС 488.4 сая, Сүмбэр сумын ОНХС 32.7 сая, Шивээговь сумын ОНХС 10.7 сая, Баянтал сумын ОНХС 24.3 сая нийт 556.1 сая, орон нутгийн давсан орлогоос аймгийн ОНХС 180.0 сая,
4. **Сумдын СХС-гийн зарлага 924.9 сая төгрөгийг:** Сүмбэр сум 774.3 сая, Баянтал сум 87.5 сая, Шивээговь сум 63.1 сая

УИХ-аас батлагдаж ирсэн төсвийн зарлагыг аймаг, сумдын ИТХ-аар батлахдаа орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого чиглэл баримтлахгүйгээр өөрийн эрх мэдлийн хүрээнд бодит тооцоо судалгаагүй, үндэслэлгүй урсгал зардлыг нэмэгдүүлсэн байна. Үүнд: Аймгийн ИТХ-ын төсвийн урсгал зардалд 69.0 сая, аймгийн Улаан загалмайн хороонд дэмжлэг 7.0 сая, Сүмбэр сумын ИТХ-ын урсгал зардалд 4.0 сая, Сүмбэр сумын ЗДТГ-ын урсгал

зардалд 6.0 сая, Шивээговь сумын ИТХ-ын урсгал зардалд 5.0 сая, “Тохижилт сүмбэр” ОНӨААТҮГ-ын урсгал зардалд 23.0 сая, нийт 114.0 сая төгрөгийг баталсан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Иймд төсвийг үндэслэлтэй баталж, тэвчиж болох зардлуудыг нэмэгдүүлж батлахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2017 онд татварын орлогын төлөвлөгөөг 764.7 сая төгрөгөөр давуулан биелүүлж, орон нутгийн төсвийн байгууллагууд 276.4 сая төгрөгийн зардлыг хэмнэж ажилласан байна

2017 оны тэнцлийн ашгийг хүнэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Д/д	Аймаг, сумдын нэр	2017 оны		Нийт дүн
		Давсан орлого	Хэмнэгдсэн зардал	
1	Аймаг	618.1	251.3	869.4
2	Сүмбэр сум	138.6	14.9	153.5
3	Баянтал сум	0.4	1.1	1.5
4	Шивээговь сум	7.6	9.1	16.7
<b>Нийт</b>		<b>764.7</b>	<b>276.4</b>	<b>1,041.1</b>

Хүснэгтээс харахад: 2017 онд 1,041.1 сая төгрөгийн тэнцлийн ашигтай гарсан байна. Тэнцлийн ашгаас 277.0 сая төгрөгийг 2018 оны төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрээр тооцож баталсан ба үлдэгдэл 764.1 сая төгрөгийн эх үүсвэрийг тооцож зардлаар батлаагүй байна.

ОНХС-ийн ажлууд тайлант ондоо багтаж хийгдээгүй он дамжсанаас нийт 675.9 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй байна. Үүнд: Аймгийн ОНХС 587.6 сая, Сүмбэр сумын ОНХС 53.1 сая, Баянтал сумын ОНХС 24.4 сая, Шивээговь сумын ОНХС 10.8 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй гарсан байна.

ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих зардлыг хүснэгтээр харуулбал

/сая төгрөгөөр/

Д/д	ОНХС-гийн нэр	2017 оны ОНХС-ийн дансны үлдэгдэл	Эхний үлдэгдлээс санхүүжихээр баталсан	Зөрүү
1	Аймгийн ОНХС	587.6	488.4	99.2
2	Сүмбэр сумын ОНХС	53.1	32.7	20.4
3	Баянтал сумын ОНХС	24.4	24.4	0.0
4	Шивээговь сумын ОНХС	10.8	10.8	0.0
<b>Нийт дүн</b>		<b>675.9</b>	<b>556.3</b>	<b>119.6</b>

Хүснэгтээс харахад: ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих зардлыг нийт 556.3 сая төгрөгөөр баталж, 119.6 сая төгрөгийг батлаагүй байна. Энэ нь 2018 оны төсвийг батлахад аймгийн ОНХС болон Сүмбэр сумын ОНХС-гийн 2017 оны төсвийн гүйцэтгэл бодитоор гараагүй байсантай холбоотой байна.

Тус аймаг нь 2018 оны эхний 9 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого, зарлагад төсвийн тодотгол хийгээгүй боловч аймгийн ИТХ-ын 2018.05.23-ний

өдрийн 03 дугаар тогтоолоор “Аймгийн 2017 оны орон нутгийн төсвийн үлдэгдлээс санхүүжүүлэх зардлын жагсаалт”-ыг 2017 оны тэнцлийн ашиг 671.1 сая, ОНХС-гийн үлдэгдэл 99.2 сая, нийт 770.3 сая төгрөгийн эх үүсвэрээр санхүүжүүлэхээр баталсан байна.

Уг тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргаас МУ-ын Ерөнхий сайдад 2018 оны 07 сарын 06-ны өдрийн А/798 тоот албан бичгээр хүсэлт хүргүүлсэн бөгөөд албан ёсоор хариу ирээгүй боловч Сангийн яамнаас зарцуулах эрхийг 9 дүгээр сард нээж, дараах зардлуудад хуваарилсан байна. Үүнд:

1. АИТХ-ын урсгал засварт 10.0 сая, хурлын даргын нөөц сангийн зардалд 20.0 сая, нийт 30.0 сая,
2. Аймгийн Засаг даргын тамгын газарт хэрэглэгчийн үнэлгээний зардалд 3.0 сая, цалин, НДШ-ийн зардалд 7.0 сая, багаж техник хэрэгсэл 4.0 сая, урсгал зардалд 9.0 сая, нийт 23.0 сая,
3. Засаг даргын нөөц санд 17.0 сая,
4. Жолоочийн хариуцлагын даатгалын санд 0.9 сая,
5. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 11.1 сая,
6. Аймгийн ОНХС, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардалд 688.3 сая,

**1.3 Тус аймаг нь 2018 онд улсын төсөвт орлого төвлөрүүлэхгүй, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авахгүй байхаар батлагдсан байна.**

Төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн үү? 2018 оны төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөсөн үү?


## Бүлэг 2

Татварын орлогын төлөвлөгөө жил бүр давж биелж байгаа нь орлого нэмэгдүүлэх нөөц боломж байгааг харуулж байна.

**2.1. Орон нутгийн татварын болон татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 213.0 сая төгрөг буюу 6.2%-иар давж биелсэн байна.**

2018 оны эхний 9 сарын байдлаар орон нутгийн татварын болон татварын бус нийт орлого 3,436.2 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөснөөс нийт 3,649.3 сая төгрөг төвлөрүүлж орлого нийт дүнгээрээ 213.0 сая төгрөг буюу 6.2%-иар давж биелсэн байна.

2018 оны 9 сарын байдлаарх орон нутгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг графикаар харуулбал:



Графикаас харахад: 2018 оны эхний 9 сарын байдлаар орон нутгийн орлогын төлөвлөгөөний биелэлт 106.2%-тай байна.

### Татварын орлогын талаар:

2018 онд Сангийн яамнаас орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 4,314.3 сая төгрөгөөр хянагдаж ирсэн бөгөөд 2017 оны 12 дугаар сард аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 100.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 4,414.7 сая төгрөгөөр баталсан бөгөөд тайлант оны эхний 9 сарын байдлаар орлогын төлөвлөгөөнд тодотгол хийгдээгүй байна.

2018 оны эхний 9 сарын байдлаарх татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь гаргасан судалгааг хүснэгтээр харуулбал:

		/сая төгрөгөөр/		
<b>ТАТВАРЫН ОРЛОГЫН НЭР ТӨРӨЛ</b>		Төлөв	Гүйц	Зөрүү
<b>Татварын орлогын нийт дүн</b>		<b>3 055,0</b>	<b>3 288,3</b>	<b>233,3</b>
1.1.Цалинхөлс түүнтэй адилтгах орлогын татвар		2 160,09	2 177,4	17,3
1.2.ХХОАТ-буцаан олголт		-300,00	-271,4	28,6
1.3.Орлогыг тодорхойлох боломжгүй иргэний татвар				-
1.4.Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татвар		85,95	98,9	12,9
1.5.Үйл ажиллагааны орлого		109,41	144,5	35,1
1.6.Хөрөнгө худалдсаны орлогын албан татвар		29,70	37,3	7,6
1.7.Үл хөдлөх хөрөнгийн албан татвар		167,35	169,3	1,9
1.8.Бууны татвар		3,57	3,2	-0,4
1.9. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар		83,00	93,4	10,4
1.10. Улсын тэмдэгтийн хураамж		41,15	82,0	40,8
1.11.Газрын төлбөр		99,00	125,8	26,8
1.12. Усны төлбөр		510,00	177,0	-333,0
1.13.Агнуурын нөөц ашигласны төлбөр			11,3	11,3
1.14.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр		0,38	28,3	27,9
1.15.Хог хаягдлын үйлчилгээний хураамж		65,40	54,8	-10,6
1.16.Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт			356,6	356,6

Хүснэгтээс харахад: татварын орлогын төлөвлөгөөний биелэлт нийт дүнгээрээ 233.3 сая төгрөг буюу 7.6%-иар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөрөө 12 нэр төрлийн орлого 1.9-356.6 сая төгрөгөөр давж, 3 нэр төрлийн орлого 10.4-65.3% буюу 0.4-333.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн болон тасарсан шалтгааныг тодруулбал:

- Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татвар – өмнөх оны өр төлөгдсөн 12.9 сая
- Үйл ажиллагааны орлого - хадгаламжийн хүүгийн орлого болон эзэмшлийн газрын эрх шилүүлсний орлогын суутгал, хот хоорондын ачаа тээврийн патентын орлого нэмэгдсэнтэй холбоотой 35.1 сая,
- Үл хөдлөх хөрөнгийн албан татвар – өмнөх оны өр төлөгдсөн болон зарим ААНБ-ууд 2018 оны татварыг бүрэн төлсөнтэй холбоотой 1.9 сая,
- Газрын төлбөр – өмнөх оны өр төлөгдсөн болон зарим ААНБ-ууд 2018 оны татварыг бүрэн төлсөнтэй холбоотой 26.8 сая
- Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар – өөр аймаг, дүүргийн татварын албанд бүртгэлтэй автомашины татварыг хураан авсантай холбоотой 10.4 сая,

- Хөрөнгө худалдсаны орлогын албан татвар – иргэдийн худалдан авалт нэмэгдсэнтэй холбоотойгоор 7.6 сая
- Улсын тэмдэгтийн хураамж – 2017 оноос газар өмчлөх эзэмшихтэй холбоотой УТХ төвлөрүүлдэг болсон, Шүүхийн шийдвэрээр улсын тэмдэгтийн хураамж өндөр дүнтэй төлөгдсөнтэй холбоотой 40.8 сая,
- Агнуурын нөөц ашигласны төлбөр – төлөвлөгдөөгүй орлогын дүн 11.3 сая,
- ТТАМНАТ – тайлант хугацааны дундуур 108 ойл ХХК нь Олон улсын чанартай терминалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор орон нутагт Сүмбэр суманд гэрээ байгуулагдсанаас шалтгаалан орлого орсон 27.9 сая,
- Дуудлага худалдааны орлого – Орлого төлөвлөгдөөгүй боловч дуудлага худалдаа зохион байгуулагдаж дэнчингийн мөнгө төлөгдсөнтэй холбоотойгоор 356.6 сая төгрөгөөр тус тус давж биелсэн бол,
- Бууны татвар – татвар бүрэн төлж дуусгах хуулийн хугацаа болоогүйтэй холбоотой 0.4 сая
- Ус, рашаан ашигласны төлбөр – Усны сав газар болон Байгаль орчин, аялал жуулчлалын газраас ус ашиглах гэрээ байгуулаагүйтэй холбоотой 333.0 сая
- Хог хаягдлын хураамж – Баянтал, Шивээговь сумд хог хаягдлын хураамжийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүйтэй холбоотой 10.6 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

**Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 20.3 сая төгрөг буюу 5.3%-иар тасарсан байна.**

2018 онд Сангийн яамнаас орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө 339.4 сая төгрөгөөр хянагдаж ирсэн бөгөөд 2017 оны 12 дугаар сард аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 71.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 411.0 сая төгрөгөөр баталсан байна.

2018 оны эхний 9 сарын татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр нь гаргасан судалгааг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		<b>381,3</b>	<b>369,5</b>	<b>-20,3</b>
2.1.	Хүү, торгуулийн орлого	340,00	326,5	-13.5
2.2.	Түрээсийн орлого	41,25	34,4	-6.8

Хүснэгтээс харахад 2018 оны эхний 9 сарын байдлаар татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 5.3% буюу 20.3 сая төгрөгөөр тасарсан бөгөөд түрээсийн орлого 16.5% буюу 6.8 сая, хүү, торгуулийн орлого 4.0% буюу 13.5 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь ОНӨГ түрээсийн орлогыг бүрэн төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

**ТЕЗ-ийн хэмжээнд төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 77.4% буюу 589.7 сая төгрөгөөр тасарсан байна.**

2018 онд Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг УИХ-аас 63.2 сая төгрөгөөр баталсан боловч аймаг, сумдын ИТХ-аар өөрийн орлогын төлөвлөгөөг нийт 955.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,019.1 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд төсөвт байгууллагын өөрийн орлого 94.2 сая, тусгай сангуудын орлого 924.9 сая төгрөг байна.

Орон нутгийн төсөвт байгууллагын болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлогын 2018 оны эхний 9 сарын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

№	Байгууллага	Жилийн төлөвлөгөө	2018 оны 9 сарын		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>Орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлого</b>						
1	АЗДТГ	0,7	0.5	1.3	-0,8	160,0
2	Цөм сүргийн үржлийн төв	30,9	15.0	4.3	10,7	-71,3
3	Авто зам	15,0	14.0	30.0	-16,0	114,3
4	Тохижилт-Сүмбэр	3,0	3.0	2.5	0,5	-16,7
<b>Дүн</b>		<b>49,6</b>	<b>32.5</b>	<b>38.1</b>	<b>-5,6</b>	<b>17,2</b>
<b>Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын өөрийн орлого</b>						
1	БТСГ	22,0	18.6	22.3	-3,7	19,9
2	Музей	0,5	0.4	0.5	-0,1	25,0
3	Номын сан	0,1	0.0	0.4	-0,4	1 233,3
4	Боржигон чуулга	18,4	13.8	15.0	-1,2	8,7
5	Шивээговь Соёлын төв	1,8	1.4	0.9	0,5	-35,7
6	Баянтал Соёлын төв	1,8	1.4	0.9	0,5	-35,7
<b>Дүн</b>		<b>44,6</b>	<b>35.5</b>	<b>40.0</b>	<b>-4,4</b>	<b>12,3</b>
<b>Сумдын сангийн орлого</b>						
1	Сумдын сум хөгжүүлэх сан	923,2	692.5	94.5	598,0	-86,4
2	Сумдын Мал хамгаалах сан	1,7	1.7		1,7	-100,0
<b>Дүн</b>		<b>924,9</b>	<b>694.2</b>	<b>94.5</b>	<b>599,7</b>	<b>-86,4</b>
<b>НИЙТ ДҮН</b>		<b>1 019,1</b>	<b>762.2</b>	<b>172.5</b>	<b>589,7</b>	<b>-77,4</b>

Судалгаанаас харахад 2018 оны эхний 9 сарын өөрийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 589.7 сая төгрөгөөр тасарсан байна. Тухайлбал, Орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлогын төлөвлөгөө 12.3-17.2%-иар тус тус давж биелсэн боловч тусгай сангуудын орлого 86.4%-иар тасарснаас шалтгаалан нийт дүнгээрээ 77.4%-иар тасарсан байна.

Өөрийн орлогын төлөвлөгөөг Цөм сүргийн үржлийн төв 10.7 сая, “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГ 0.5 сая, сумдын Соёлын төв тус бүр 0.5 сая, сумдын сангуудын орлого 599.7 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэснийг тус тус зөрчсөн байна.

2018 оны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг УИХ-аас 644.6 сая төгрөгөөр хянаж баталсан ба эхний 9 сарын байдлаар орлогын дүнд өөрчлөлт ороогүй бөгөөд 502.9 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарийн дагуу бүрэн олгосон байна.

2018 оны Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг УИХ-аас 8,324.4 сая төгрөгөөр баталсан байна. Уг дүнд өөрчлөлт ороогүй бөгөөд ТЗШ-ийн байгууллагуудын санхүүжилт эхний 9 сарын байдлаар 5,949.9 сая төгрөгөөр төлөвлөгдөж, гүйцэтгэлээр 5,948.1 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд 99%-ийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь насан туршийн боловсролын 1 792.9

мянган төгрөгийн санхүүжилт дутуу орж ирснээс Сүмбэр сумын 1 дүгээр сургуульд дээрхи дүнгээр санхүүжилт дутуу олгогдсон байна.

## 2.2. Төсөвт байгууллагын өөрийн орлого болон өмнөх оны татварын өрийн судалгаа гаргаж тооцсоноор орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэх боломжтой байна.

Аймгийн СТСХ болон Татварын хэлтсээс өмнөх оны татварын төлөгдөөгүй үлдэгдлийг тодорхой тооцоогүй, мэдээллийн сан үүсгээгүйтэй холбоотойгоор орлого нэмэгдүүлэх боломжийг үнэн зөв тооцож батлуулаагүй байна. Тухайлбал өмнөх оны төлөвлөгөө 636.0 сая төгрөгөөр давж биелсэн байхад 2018 оны орлогын төлөвлөгөөг 332.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Аймгийн Номын сангийн өөрийн орлогыг өмнөх оноос 90%-иар буюу 0.4 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн бөгөөд энэ нь Сангийн яамнаас ирүүлсэн төсвийг нэмэгдүүлэлгүй батлуулсантай холбоотой байна.

2018 оны батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулж буй эсэх

## Бүлэг 3

Төсвийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйгээс бодит бус хэмнэлт үүссэн байна

### 3.1. Төсвийн хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

2018 оны 03 дугаар улирлын байдлаар нийт 12,896.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 10,440.5 сая төгрөгийг зарцуулж төсвийг 2,456.1 сая төгрөгөөр буюу 19.0%-иар хэмнэж ажилласан байна.

2018 оны 03-р улирлын аймгийн батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

№	Зардал бүлгийн төрлөөр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүн	Хувь
1	Цалин, нэмэгдэл урамшил	4,889.8	4,696.7	193.1	3.9
2	НДШ-ийн зардал	587.2	560.0	27.2	4.6
3	Тогтмол зардал	938.7	826.5	112.2	12.0
4	Хангамж, бараа материалын зардал	202.3	180.7	21.6	10.7
5	Нормативт зардал	327.6	250.0	77.6	23.7
6	Эд хогшил, урсгал засварын зардал	127.2	87.9	39.3	30.9
7	Томилолт, зочны зардал	35.3	25.4	9.9	28.0
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	269.2	176.7	92.5	34.4
9	Бараа үйлчилгээний бусад зардал	896.9	615.1	281.8	31.4
10	Татаас	156.6	144.9	11.7	7.5
11	Бусад урсгал шилжүүлэг	2,024.8	1,870.8	154.0	7.6
12	Хөрөнгийн зардал	1,748.6	873.4	875.2	50.1
13	Эргэн олгох зээл	692.4	132.4	560.0	80.9
<b>Нийт зардлын дүн</b>		<b>12,896.6</b>	<b>10,440.5</b>	<b>2,456.1</b>	<b>19.0</b>



Хүснэгтээс харахад: 2018 оны эхний 9 сарын байдлаар нийт 2,456.1 сая төгрөг хэмнэсэн бөгөөд хэмнэлтийн шалтгааныг тодруулбал:

1. Цалин, НДШ-ийн зардал: ССЗДТГ, 2-р цэцэрлэг, АЗДТГ, Боржигин чуулга орон тоо дутуу ажилласан, Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэг 9 дүгээр сард ашиглалтанд орсон
2. Тогтмол зардал: Сүмбэр сумын 6 дугаар цэцэрлэг 9 дүгээр сард ашиглалтанд орсон, Сүмбэр сумын ЗДТГ-т халаалтын зардал илүү хуваарилсан, 2-р сургуульд 5-р сард халаалтын зардал хуваарилсан, Шивээговь сумын Эрүүл мэндийн төв нь хуучин эмнэлгийн барилгыг ашиглаагүйтэй холбоотой
3. Нормативт зардал: Цэцэрлэгүүдийн хүүхдийн хоолны зардалд гүйцэтгэлээр нь санхүүжилтийг олгосон, хичээлийн амралтын хугацаа, хүнсний нөөц бүрдүүлээгүй
4. Урсгал засварын зардал: Аймаг, сумдын Засаг даргын тамгын газрын урсгал засварыг 3 дугаар улирлын байдлаар хийж гүйцэтгээгүй
5. Эд хогшилын зардал: АИТХ, Автозамын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын 4 замын уулзварт гэрлэн дохио суурилуулах ажлын тендер хойшилсон, ГХБХБГ-ын шинэ лабораторийн багаж, тоног төхөөрөмж, тавилга, хашаа авах талаар Төрийн өмчийн хороонд саналаа 2 сард явуулсан боловч хариу шийдэгдэж ирээгүй
6. Бараа ажил үйлчилгээний бусад зардал: Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал нь услалтын систем хөв цөөрөм байгуулах ажлын зураг төсөв боловсруулах ажлын гэрээ хойшилсноос болж бусад ажлуудын гэрээ хойшилсон, аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний зардлын төсвийг жигд хуваарилсан,
7. Татаас : Нийтийн тээврийн хөнгөлөлтийн зардлыг сар бүр тэгш хуваарилсан, олгогдоогүй тэтгэвэр тэтгэмжийн зардал, сургуулиудын үдийн цайны зардлыг гүйцэтгэлээр олгосноос хэмнэсэн, ГБХЗХГ-ын нягтлан бодогчийн тэтгэврийн зардал, БСШУСЯ-ны харъяа байгууллагуудын төсвийн хуваарьт төрийн албан хаагчид олгох нэг удаагийн тэтгэмжийн 300.0 мянган төгрөгийн зардлыг 6 дугаар сард хуваарилсан
8. Хөрөнгийн зардал: Орон нутгийн хөгжлийн сангуудын хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэл дутуугаас санхүүжилтийг олгоогүй
9. Эргэн олгох зээл: Сумдын сум хөгжүүлэх санд зээлийн эргэн төлөлт хийгээгүйгээс зээл олгогдоогүй зэрэг шалтгаантай байна.

Дээрх хэмнэлтийн шалтгаанаас харахад төсвийн захирагч нар төсвийн удирдлага зохион байгуулалтыг зөв зохистой хэрэгжүүлээгүй, төлөвлөгдсөн ажлууд хугацаандаа хийгдээгүй, төсвийн хуулийн хэрэгжилт хангалтгүйгээс бодит бус хэмнэлт үүссэн байна

Тус аудитаар аймгийн төвийн 3, Сүмбэр сумын 4, Шивээговь сумын 6, Баянтал сумын 6, нийт 18 төсөвт байгууллагыг түүвэрлэн авч 2018 оны Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцыг шалгалаа.

Сумдын Санхүүгийн албанаас 2018 оны эхний хагас жилийн байдлаар төсөвт байгууллагуудад явцын хяналт шалгалт огт хийгдээгүй, арга зүйн зөвлөмж өгөөгүй байна. Тухайлбал: сумдын Санхүүгийн алба төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланг нэгтгэхдээ өглөг, авлагыг тулган баталгаажуулаагүй, санхүүгийн тайлангийн тоон мэдээллийг нэмж нэгтгэх төдийхнөөр тайланг хүлээн авсан байна.

Төсвийн байгууллагуудад сахилга хариуцлагын жилтэй холбогдуулан гаргасан Засгийн газрын тогтоол, аймгийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, төсөвт байгууллагуудын өр, авлагыг нэмэгдүүлсэн, өр, авлага нэмэгдсэн шалтгааныг тодруулж, дүн шинжилгээ хийгээгүй, АШБ-ын бүрдэлтгүйгээр ажил гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна.

Аудитын явцад нягтлан бодогч нар ажил үүргээ хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлээгүй, ажлын гүйцэтгэл хангалтгүй, мэдлэг, ур чадвар дутмаг, байгууллагын удирдлагууд, Санхүүгийн алба, нягтлан бодогч нарын ажлын уялдаа холбоо муу, санхүүгийн тайланг хүлээн авч хянах, тулган баталгаажуулах үйл ажиллагаа хангалтгүй, алдаатай тоо, мэдээг нэгтгэж байна.

Аудитын явцад зөрчил дутагдал гаргасан нягтлан бодогч болон хяналтын чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлээгүй төсвийн захирагч, санхүүгийн албаны дарга, төрийн мэргэжилтэн нарт хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

### **3.2. Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.**

2018 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу аймгийн ОНХС болон улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй 37 төсөл арга хэмжээний худалдан авалтын 36 нь цахим, 1 нь уламжлалт, сумдын ОНХС-гийн 25 төсөл, арга хэмжээний худалдан авалтын 6 нь цахим, 19 ажлыг уламжлалт аргаар тус тус шалгаруулсан байна. Тухайлбал: 10.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтыг цахим [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) системээр тендер шалгаруулалтыг нээлттэй болон харьцуулалтын аргаар, шууд худалдан авалтыг уламжлалт аргаар тус тус зохион байгуулсан байна.

2018 онд аймагт Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2, улсын төсөвт байгууллагуудын 12, нийт 14 ажлын 1,410.7 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 1 ажлын 160.0 сая, АОНХС-гаар 15 ажлын 1,237.0 сая, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар 7 ажлын 169.8 сая, нийт 37 ажлын 2,978.3 сая төгрөгийн тендер зарлахаас 27 ажлын 2,217.7 сая төгрөгийн тендер шалгалуулалтыг гэрээг байгуулсан байна.

Тендер шалгаруулалт хийгдээгүй 10 ажлаас 6 ажлын 570.7 сая төгрөгийн ажлын тендерийн баримт бичгийг боловсруулж, 3 ажлын 90.0 сая төгрөгийн ажлын тендерийн үнэлгээг хийж, 1 ажлын 100.0 сая төгрөгийн тендерийг зарласан байна.

Сумдын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 25 ажлын 380.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалт батлагдсанаас 22 ажлын 354.5 сая төгрөгийн тендер шалгаруулалтыг хийж гэрээг байгуулсан, 5.0 сая төгрөгийн 1 ажлын тендерийн баримт бичгийг боловсруулж, 21.0 сая төгрөгийн 2 ажлын даалгавар, ТЭЗҮ ирүүлээгүйгээс тендер шалгаруулалт нь хийгдээгүй байна.

## Бүлэг 4

**Төсөв захирагчдын хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг тодорхой батлаагүйгээс дүгнэлт өгөх боломжгүй байна.**

### **4.1 Төсөв захирагчдын хэрэгжүүлж буй хөтөлбөр арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтийг тодорхой батлаагүй байна.**

Аймгийн ИТХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн 4 дүгээр хуралдааны 04 тоот тогтоолоор аймгийн “Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”- ийг 32 зорилт, 119 арга хэмжээ хэрэгжүүлэхээр, мөн 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 04 дүгээр хуралдааны 07 тоот тогтоолоор аймгийн “Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг 5 салбарт, 36 зорилт, 116 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр тус тус баталсан байна,

Аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2018 онд Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэхээр салбарын сайдуудтай гэрээ байгуулан ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 9 дүгээр хуралдааны 08 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон хэмжээний үзүүлэлт, 2018 оны зорилтод түвшинг баталсан байна.

Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.4-д “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга (хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан)” нь төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн байна гэж заасны дагуу жил бүр хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнг дүгнэж тайлагнаагүй, төсвийн гүйцэтгэлийг тохируулах байдлаар тайлагнаж ирсэн байна.

### **4.2 Төсөв захирагчид 2018 оны Төсвийн хуулиар батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд дүгнэлт өгөх боломжгүй байна.**

Аймаг, сумын ИТХ-аас төсөв захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын хэмжээний үзүүлэлт, зарцуулах төсвийг зохистой хэмжээнд төлөвлөж батлаагүй байна.

Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын хэмжээний үзүүлэлтийг тайлант онд зарцуулах төсөвтэй уялдуулан батлахгүй байгаа нь хөтөлбөр, арга хэмжээг зориулалтын дагуу зарцуулж буй эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй байна.

### **4.3 Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй байна.**

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь 2018 оны төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтуудыг хийж байгаа боловч 2018 оны төсвийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын сайд

нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг гаргуулан холбогдох байгууллагуудад хүргүүлж ажилласан байна.

2018 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр 54%, аймгийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл 50.6%-тай тус тус дүгнэгдсэн байна.

Тус хэлтсээс 2018 оны эхний хагас жилийн байдлаар төсвийн орлогын бүрдүүлэлт болон зарцуулалт, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна

Аудитаар нийт 1,185.9 сая төгрөгийн зөрчил, дутагдал илрүүлснээс 3.9 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 600.4 сая төгрөгийн албан шаардлага, зөрчил дутагдлыг арилгуулах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

## ДҮГНЭЛТ

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.**

1. УИХ-аас баталсан төсвийг жил бүр нэмэгдүүлэн баталж байгаа нь төлөвлөлт бодитой бус, үндэслэлгүй байгааг харуулж байна.
2. Татварын орлогын төлөвлөгөө жил бүр давж биелж байгаа нь орлого нэмэгдүүлэх нөөц боломж байгааг харуулж байна.
3. Төсвийн удирдлагыг зохистой хэрэгжүүлээгүйгээс бодит бус хэмнэлт үүссэн байна
4. Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын хэмжээний үзүүлэлтийг тайлант онд зарцуулах төсөвтэй уялдуулан батлаагүй байна.
5. 2018 оны 03 дугаар улирлын байдлаар төсвийн орлогын бүрдүүлэлт болон зарцуулалт, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй байна

## ЗӨВЛӨМЖ

**Аймгийн Засаг дарга Г.Батсуурь танаа**

1. Төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг сайжруулах
2. 2018 оны орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлэхэд анхаарч ажиллах
3. Төсвийн удирдлагыг зохистой хэрэгжүүлж, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулах,
4. Төсвийн хуулийн хэрэгжилтийг бүх шатанд хангаж ажиллах
5. Төсвийн эрх захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын хэмжээний үзүүлэлтийг тодорхой гаргаж, тайлант онд зарцуулах төсөвтэй уялдуулан батлуулж байх

# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

42000 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,  
Утас/Факс: (946) 7054 3005, И-мэйл: zdtg.gsa@gmail.com,  
Вэбсайт: www.govisumber.gov.mn

2018. 09. 05 № 9/1266

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай ирүүлсэн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явцад хийсэн тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайланд өгөх санал тайлбар байхгүй болно.

ОРЛОГЧ ДАРГА



Ш БИЛЭГГҮМБЭРЭЛ

*Ц.Батсайханд  
Тайланг оруулна  
2018/09/05*

02 0574

## **ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ХИЙСЭН ТАЙЛБАР**

Аймгийн ТЕЗ-ийн ирүүлсэн саналтай танилцаад тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2018 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/23

Чойр

Аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.5 Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12 дугаар зүйлийн 12.40, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/124 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам"-ын 13 дугаар зүйлийн 13.9, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.2, 2.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторт 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамжаар "2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц"-д хийгдсэн аудитын тайлан, илэрсэн зөрчлийн жагсаалт, акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

2. "2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийн явц"-д хийгдсэн аудитын тайланг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, тогтоогдсон акт, албан шаардлагыг барагдуулж, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2019 оны 03 дугаар сарын 25-ны дотор Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Б.Анхтуяа нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.САРАНТУЯА

D:\DOTOOD AJIL\TUSHAAL.doc

ᠮᠣᠩᠭᠣᠯ